



МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ХУРЛЫН
ТОГТООЛ

2015 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Мал эмнэлэг, үржлийн газрын үйл ажиллагааны үр дүнг
дээшлүүлэх талаар гаргасан зөвлөмжийн тухай

Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн хоёрдугаар зүйлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал эмнэлэг, үржлийн газрын үйл ажиллагаанд 2012 онд хийсэн дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилт болон 2013-2014 онуудын улсын төсвийн санхүүжилт, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, үр дүнд Хүнс, хөдөө аж ахуйн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын гүйцэтгэлийн болон санхүүгийн аудит хийсэн тайлангай танилцаж, Дотоод аудитын хөрөөгоор хэлэлцүүлсэн зөвлөмжийг хавсралтад тусгаснаар хэрэгжүүлсүгэй.
2. Зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах удирдлагын хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан 10 хоногийн дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг Мал эмнэлэг, үржлийн газрын дарга /М.Галбадрах/-д үүрэг болгосугай.
3. Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хяналтад авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /У.Сауле/-д үүрэг болгосугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН



Р.БУРМАА

**Мал эмнэлэг, үржлийн газрын үйл ажиллагааны үр дүнг
дээшлүүлэх талаар гаргасан зөвлөмжийн тухай**

Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн удирдамжийн дагуу Мал эмнэлэг, үржлийн газрын (МЭҮГ) үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, түүний хэрэгжилтийн үр дүнд гүйцэтгэлийн болон санхүүгийн дотоод аудит хийсэн дүгнэлт, зөвлөмж:

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ СТРАТЕГИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАРТ**

1. МЭҮГ-ын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, **Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай** хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.7-д “Монгол Улсад үржүүлж байгаа үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсэг, омог, хэвшлийн малыг бүртгэх, хяналт тавих, олон улсын малын удмын сангийн нэгдсэн сүлжээнд оруулах”, 15 дугаар зүйлийн 15.1.8-д “... малын удам гарвалийн бүртгэл, мэдээллийн сан, сүлжээ бий болгон ажиллуулахад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх”, **Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай** хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д “Мал, мах бэлтгэх, гарал үүслийн гэрчилгээний загвар батлах, олгох”, 11 дүгээр зүйлийн 11.5-д “...нийт малыг бүртгэх бүртгэлийн тухай бүр шинэчлэх” заалтууд, Засгийн газрын 2015 оны 01 дүгээр сарын 12-ны 8 дугаар тогтоолыг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 02 дугаар сарын 09-ний А/18 тоот тушаалаар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын бүтцэд Мал эмнэлгийн хэлтэстэй байхаар баталсан бөгөөд Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагаас 2007, 2010, 2012 онуудад хийсэн хөндлөнгийн эрсдлийн үнэлгээний дүн, дүгнэлт, зөвлөмжид тулгуурлан мэргэжлийн босоо тогтолцоотой, шуурхай удирдлагын нэгж бүрдүүлж байгууллагын бүтэц тогтолцоо, үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан МЭҮГ-ын өгсөн саналын дагуу өөрчилж шинэчлэн батлах. Үүнд: Мал эмнэлгийн хэлтсийг ахин бий болгож тус газрыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах, бүртгэл мэдээллийн асуудал хариуцсан 3 мэргэжилтэнтэй байх;

2. Малын үржлийн ажил, үйлчилгээний зардлаас хяналтын зардлыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад үлдээж, үндсэн ажил, үйлчилгээний зардал, санхүүжилтийг МЭҮГ-ын төсөвт суулган санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

3. Хүнс, хөдөө аж ахуйн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Мал эмнэлэг, үржлийн газрын Мал үржлийн хэлтэс, Малын удмын сангийн үндэсний төв (МУСҮТ)- ийн үйл ажиллагааны давхардлыг арилган, ажил, үйлчилгээний хариуцах чиг үүргүүдийг тодорхой заасан Хүнс, хөдөө аж ахуйн сайдын шийдвэр гаргуулах;

4. Харьяа мэргэжлийн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж буй төсвийн байгууллагын төсвийн төлөвлөгөөний санал, судалгаа дүгнэлтийг үндэслэн төвлөрсөн арга хэмжээ болон хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөгөөг боловсруулан, хүрэх үр дүнг тодорхой тооцон холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх, санал тавиагүй арга хэмжээнд төсвийн хөрөнгө төлөвлөх асуудлыг бүрэн зогсоох;

МАЛ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗАРТ

1. Хүнс, хөдөө аж ахуйн сайдын “Төсвийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх төвлөрсөн арга хэмжээний болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлах тухай” 2015 оны А/08 тоот тушаалын II хавсралтад тусгагдсан малд ангилалт хийх, үржилд ашиглах малыг баталгаажуулах зардалд 200.0 сая төгрөг баталсан бөгөөд эхний ээлжинд Төрийн өмчийн цөм сүргийн үржлийн аж ахуйн төвүүдийн малыг бүрэн хамруулах, Эрчимжсэн мал аж ахуйд дэмжлэг үзүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгөнөөс олгосон зээл, дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн малыг тус тус ангилж баталгаажуулах, хяналтын зардлыг санхүүжүүлэн хэрэгжүүлэх;

2. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.2.”мал эмнэлэг, үржлийн албыг бодлогын болон мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдамжаар хангах, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн “Малын үржлийн ажил, үйлчилгээг нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн төгс чанартай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх”, “Мал эмнэлгийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, малын эрүүл мэндийг баталгаажуулах замаар нийгмийн эрүүл мэндийг хамгаалах” тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Мал эмнэлэг, үржлийн газар, Малын удмын сангийн үндэсний төв, Мал аж ахуйн хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэнгүүдийн хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ

Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2013 онд “Ариутгал халдваргүйжүүлэлтийн зөөврийн угаалгын ванн” МЭТШ/2013/05 тендерээр нийлүүлэгдсэн хөрөнгийг Дундговь аймгийн Цагаандэлгэр суманд шилжүүлснийг тус сумын удирдлага дахин тендер зарлан баримт бүрдүүлэн Тэвшийн наран ХХК-ны дансанд орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөгийн санхүүжилт хийж, сумын нягтлан бодох бүртгэлд мал угаалгын ванныг 5,0 төгрөгөөр бүртгэсэн байна. Иймд: Дундговь аймгийн ХХААГ, Цагаандэлгэр сумын Засаг даргын тамгын газарт албан тоот хүргүүлж, ХХААГ-ын холбогдох албан тушаалтан, сумын Мал эмнэлэг, үржлийн тасгийн даргад хариуцлага тооцох асуудлыг уламжлан шийдвэрлүүлэх.

МАЛ ЭМНЭЛЭГ, ҮРЖЛИЙН ГАЗАРТ

1. Мал эмнэлэг, мал үржлийн талаар төрөөс баримталж буй стратеги бодлого, төлөвлөгөөт арга хэмжээ, хэрэгжилтийг нарийн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах, үр дүнд хяналт тавих, мэргэшсэн мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ, хангамж, хүний нөөцийн чадавхийг бүрдүүлэн бүтцийн өөрчлөлтөд тусгах;

2. Мал эмнэлэг, үржлийн арга хэмжээ, түүнд шаардагдах зардлыг орон нутгийн онцлог, ирүүлсэн саналыг хянан тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн оновчтой төлөвлөх, батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулж, үр дүнд суурилсан санхүүжилтийн зарчмыг хэрэгжүүлэх, өндөр үнэтэй техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг хэрэгцээтэй газарт нь хуваарилан эзэмшилт, ашиглалтыг сайжруулах, хяналт тавих;

3. Улсын төсвийн хөрөнгөөр 2013, 2014 онуудад нийлүүлэгдсэн мал угаалгын ванныг сумдын данс бүртгэлд тусгасан байдалд дотоод хяналт тавьж, бараа материал, хангамжийн материал зэрэг өөр өөр дүнгээр харилцан адилгүй тайлан тэнцэлд тусгасан, огт тусгаагүй зөрчлийг арилгуулж “үндсэн хөрөнгө”-д бүртгүүлэх, залруулах бичилт хийлгэх;

4. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.”төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” зарчмыг бүрэн хэрэгжүүлж, он дамжсан өр, авлага үүсгэхгүй байхад анхаарч ажиллах;

5. Төсвийн ил тод байдлыг ханган, ажилтан албан хаагчдад батлагдсан төсвийн төлөвлөгөө, хуваарь, цалин хөлстэй холбоотой мэдээллийг тухай бүр хүргэх, Хөдөлмөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1.”үндсэн цалингийн хэмжээг тогтоох, нэмэгдүүлэх, түүний хэлбэр, олгох хугацаа, нэмэгдэл хөлс, шагнал урамшил, нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, олговрын хэмжээ, хөдөлмөрийн норм, нормативыг тогтоох, өөрчлөх, ажилтанд олгох хоол, унааны зардал болон бусад нөхөн олговрын хэмжээг тогтоох” гэж заасны дагуу “Мал эмнэлэг, үржлийн газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 15.3-д төрийн албан хаагчдад олгох үдийн хоолны хөнгөлөлт, нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зардлын дүнг бодитой, тодорхой тусгах;

6. Төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах талаар санаачлагатай ажиллах, тендерээр худалдан авах хөрөнгийн зах зээлийн үнэ ханшны судалгааг хийж, тендерийн баримт бичигт нийлүүлэх бүтээгдэхүүний доод тоо хэмжээг тодорхой тусгаж өгөх;

7. Мал үржлийн ажлын стратеги төлөвлөгөөний дагуу малын үржлийн ажил, үйлчилгээг чанаржуулж, гүйцэтгэлийн үр дүнг тооцох, батлагдсан үүлдэр омгийн малын генийн санг хамгаалах, үүлдэрлэг байдлын стандартад заасан ашиг шимийн үзүүлэлтийг бууруулахгүй өсгөн үржүүлэх, үржлийн болон цөм сүргийн малд явуулах үзлэг, ангилалтыг мал ангилалтын заавар, стандартыг баримтлан үүлдэр, омгийн өвөрмөц хэв шинж, ашиг шимийн хэмжих үзүүлэлтүүдийг мөрдлөг болгон явуулж тайланд тусгах;

8. ХХААХҮ-ийн сайд, БСШУ-ны сайдын 2009 оны 102/175 дугаар тушаалын 2 дах заалтын дагуу “Малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөө”-ний I үе шатны биелэлтийг гаргаж, явц, үр дүнг 2015 оны IV улиралд ТНБД-ын зөвлөлийн хуралдаанд танилцуулах;

9. Малын бүртгэл, мэдээллийн сан, сүлжээ бий болгох, ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах, ажиллах хүчний нөөц бололцоог бодитой төлөвлөх, орон нутагт олгож буй мал ээмэгжүүлэлтийн ажлын үйлчилгээний хөлсийг өнөөгийн зах зээлийн бодит жишигт нийцүүлэн тооцоо, судалгааг хийх, бүртгэлийн гэрчилгээ, малын шилжилт, хөдөлгөөний бүртгэл хөтлөх зэрэг асуудлуудыг холбогдох дүрэм, журам, шаардлагад нийцүүлэн зохион байгуулж өөрчлөх;

10. Сумдын МЭҮТ-ийн мэргэжилтнүүдийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт харьяалуулан мэргэжил арга үйн удирдлагаар хангах, үйл ажиллагааны санхүүгийн зардлыг хуваарилан олгох саналыг боловсруулан Хүнс, хөдөө аж ахуйн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх;

11. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, биобэлдмэлийг аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газруудаас ирүүлсэн захиалгыг үндэслэн төлөвлөгөөнд тусгаж хуваарилах;

12. Мал угаалгын ванныг ашиглах сургалтыг нийлүүлэгч байгууллагатай хамтран, олгосон аймаг, сумдад сургалт зохион байгуулж, цаашид ашиглах бололцоотой эсэхэд эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулж, үр дүнг танилцуулах.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР